



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар Б/247

Улаанбаатар хот

Ү.Түмэндэмбэрэлийг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.3, Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Өндөр хүчдэл түгээх төвийн Агаарын шугамын засварын монтер Үржингийн Түмэндэмбэрэл /121571/-ийг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Ү.Түмэндэмбэрэлд эрчим хүчний салбарт 20 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 26.880.000 /хорин зургаан сая найман зуун наян мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Ү.Түмэндэмбэрэлийн ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын суутгалыг 6.99 хоногоор тооцож, холбогдох тооцоог хийж дуусгахыг Өндөр хүчдэл түгээх төвийн дарга /Ж.Баатархүү/-д үүрэг болгосугай.

4. Ү.Түмэндэмбэрэлд нэг удаагийн тэтгэмжийн 26.880.000 /хорин зургаан сая найман зуун наян мянга/ төгрөг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Р.ДАГДАН



e:\2021 он\ashigfalt-2\эхнх\тэтгэвэрт гаргах.docx

3170601781